


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нийт 50 даалгавартай бөгөөд 1-25 дугаар даалгавар тус бүр 1 оноо, 26-41 дүгээр даалгавар тус бүр 2 оноо, 42-50 дугаар даалгавар тус бүр 3 оноотой. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

- Цагаан будааг хамгийн бага тариалдаг улс аль нь вэ?
 A. Хятад
 B. Энэтхэг
 C. Вьетнам
 D. Хойд Солонгос
 E. Индонез
- Таримал ургамал үүссэн төвүүдийг харуулсан зурагт Этиопийг хэдийн тоогоор тэмдэглэсэн бэ?



- 8
- 7
- 6
- 4
- 5

- Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Далайн тусгаар хэсгүүдийг холбож буй харьцангуй нарийн хэсгийг гэнэ.
 A. арал
 B. булан
 C. садраа эрэг
 D. хойг
 E. хоолой
- Монгол улсын эдийн засгийн Төвийн бүсэд хамрагдах аймгууд аль нь вэ?
 A. Говьсүмбэр, Төв, Дорноговь, Сэлэнгэ, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь
 B. Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь
 C. Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр
 D. Төв, Орхон, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Дорноговь
 E. Төв, Орхон, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр
- Аль улс нь хаант засаглалтай вэ?
 A. Бутан
 B. Сингапур
 C. Хойд Солонгос
 D. Өмнөд Солонгос
 E. Энэтхэг
- Дэлхийн өвлийн аялал жуулчлалын гол бүс нутаг аль нь вэ?
 A. Альпийн нуруу
 B. Уралын нуруу
 C. Атласын уулс
 D. Их Ус хагалбарын нуруу
 E. Кавказын нуруу
- Далайд гарцгүй Европын улс аль нь вэ?
 A. Унгар
 B. Испани
 C. Франц
 D. Финлянд
 E. Дани

8. Цэгийн оронд байх зөв утгыг сонгоно уу. Дэлхийн гадаргын ямар нэг цэгийн соронзон голдочийн хавтгай ба түүнийг дайран гарах босоо хавтгайн хоорондох өнцгийг гэнэ.
- A. соронзон шуурга
B. соронзон туйл
C. соронзон гаж
D. соронзон гүр
E. соронзон азимут
9. Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий газрыг юу гэж нэрлэдэг вэ?
- A. Дурсгалт газар
B. Байгалийн цогцолборт газар
C. Дархан цаазат газар
D. Байгалийн нөөц газар
E. Шим мандлын нөөц газар
10. Орхон гол хаанаас эх авдаг вэ?
- A. Хянганы уулсаас
B. Хангайн нуруунаас
C. Хэнтийн нурууны баруун өмнө хажуугаас
D. Монгол Алтайн Таван богд уулнаас
E. Хэнтийн нурууны зүүн хойд хажуугаас
11. Цэгийн оронд тохирох үгийг олно уу. тоо толгойгоор улс дэлхийд хоёрдугаарт ордог. Дангаар нэг эх газрыг эзлэн орших энэ нутгийн төв хэсэгт байдаг.
- A. Адууны, Хятад, өндөр уулс
B. Хонины, Австрали, цөл
C. Хонины, Австрали, өтгөн навчит ой
D. Ямааны, Австрали, өндөр уулс
E. Гахайн, Хятад, цөл
12. Хойд мөсөн далайн ай савд хамаарах гол аль нь вэ?
- A. Сэлэнгэ, Туул
B. Онон, Онги
C. Тэс, Буянт
D. Завхан, Таац
E. Улз, Байдраг
13. Монгол улсын зүүн захын цэгийн солбицол аль нь вэ?
- A. х.ө $46^{\circ} 52'$ з.у $103^{\circ} 50'$
B. х.ө $48^{\circ} 53'$ з.у $87^{\circ} 44'$
C. х.ө $46^{\circ} 43'$ з.у $119^{\circ} 56'$
D. х.ө $52^{\circ} 09'$ з.у $98^{\circ} 57'$
E. х.ө $41^{\circ} 35'$ з.у $105^{\circ} 00'$
14. Манай улс хэдэн оноос дэлхийн цагийн бүсийг албан ёсоор авч хэрэглэсэн бэ?
- A. 1921
B. 1930
C. 1961
D. 1978
E. 1987
15. Дараах нууруудаас аль нь мөстлөгийн гаралтай вэ?
- A. Толбо, Даян
B. Буйр, Хөвсгөл
C. Хөвсгөл, Тэрхийн цагаан
D. Тэрхийн цагаан, Хагийн хар
E. Толбо, Хяргас
16. Г.Е.Грумм- Грижимайло Монгол Алтай, Хархираа, Увс нуурын орчмын байгаль, хүн ам угсаатны зүйг судалж ном бичжээ. Энэ номын нэрийг олно уу.
- A. Баруун Монгол ба Урианхайн хязгаар
B. Орчлонгийн элдэв сонин
C. Баруун хойд Монголын тодорхойлолт
D. Монгол орны физик газарзүйн тодорхойлолт
E. Монгол ба Кам


17. Манай улсын аль аймаг БНХАУ-ын Шинжаан-Уйгуртай хиллэдэг вэ?

- A. Ховд
B. Дорноговь
C. Сүхбаатар
D. Дорнод
E. Увс

18. Африк тивийн хөгжингүй улс аль нь вэ?

- A. ӨАБНУ
B. Египт
C. Алжир
D. Судан
E. Кени

19. Дараах бүдүүвчид байгаа асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олно уу?



- A. ажилгүйдлийн жирийн түвшин
B. ажилгүйдлийн өндөр түвшин
C. энгийн ажилгүйдэл
D. ажлын байрны хангамж
E. ажилгүйчүүд

20. Биологийн олон янз байдлын тухай конвенцид манай улс 1993 онд нэгдэн орсон. Амьтдыг нэн ховор, ховор, элбэг гэж гурав ангилна. Доор дурьдсан амьтдаас нэн ховор амьтад аль нь вэ?

- A. Шивэр хандгай, ирвэс, хүдэр, минж, халиу
B. Ирвэс, чоно, бүргэд, минж, нугас
C. Цагаан зээр, ирвэс, минж, халиу
D. Тарвага, шивэр хандгай, буга, баавгай
E. Тас, элээ, минж, ирвэс

21. Дараах үйл явцуудын аль нь органик өгөршилд хамрагдах вэ?

- A. Уулын чулуулаг салхины нөлөөгөөр бутрах
B. Температурын зөрүүнээс болж чулуулаг үйрч бутрах
C. Боржин өгөршиж шаазангийн шавар болох
D. Хүндийн хүчний нөлөөгөөр гүдгэр гадаргуугаас хөндийрүү шилжих, бутрах
E. Ургамлын үндэсний хөгжлөөс болж чулуулаг бутрах

22. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Хүйтэн бүслүүр нь туйл талаасаа хамгийн дулаан сарын⁰С-ийн изотермээр зааглагдана.

- A. +20 B. 0 C. +10 D. -5 E. -10

23. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. байшин барилга, зам талбай, өвс ургамал, ойд модыг гэмтээж хөрсний үржил шимд муугаар нөлөөлнө. Ялангуяа өндөр болон сэрүүн өргөргийн шилмүүст моддод бүр ч их нөлөөлөх ба модны үндсийг ч гэмтээдэг.

- A. хүчиллэг бороо
B. шүлтлэг бороо
C. цас
D. нойтон цас
E. шиврээ бороо

24. Дараах хариултуудаас 1:100 000 масштабтай зургийн хуудасны нэрлэлийг сонгоно уу.

- A. L-48-A D. L-48-96-A
B. L-48 E. L-48-96-A-a
C. L-48-123


25. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Тодорхой тоон үзүүлэлтийг төлөөлсөн цэгийн тусламжтайгаар үзэгдлийн тархалт, байршлыг илэрхийлэх аргыг гэнэ.

- A. цэгийн арга
- B. талбайн арга
- C. ижил шугамын арга
- D. тэмдэгтийн арга
- E. хөдөлгөөнт шугамын арга

26. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг хэрхэн тооцоолдог вэ?


- A. Ажиллагсад
- B. Ажилгүйчүүд
- C. Нийт хүн амаас нийт хүүхдийн тоог хасна
- D. Ажил идэвхтэй хайж байгаа хүмүүс + нийт хүүхдийн тоо
- E. Ажилгүйчүүд + Ажиллагсад

27. Дараах бүвүүвчийн хоосон нүдэнд тохирох үгийг сонгоно уу.




- A. хөдөлмөрийн нөөц
- B. капитал
- C. үйлдвэрлэлийн үйл явц
- D. зах зээл
- E. газрын баялаг

28. Хөрсний зүсэлтийн зурагт В үсгээр юуг тэмдэглэсэн бэ?



- A. Дээд хөрс
- B. Доод хөрс
- C. Гадарга
- D. Эх чулуулаг
- E. Угаagdлын үе

33. Б.П.Алисовын ангилалаар хийгдсэн Евразийн уур амьсгалын бүсийн зурагт 2-ын тоогоор ямар бүсийг тэмдэглэсэн вэ?



- A. Тропикийн
- B. Экватор орчмын
- C. Сэрүүн
- D. Туйл орчмын
- E. Туйлын

34. Арлуудыг орших далайтай нь зөв тохируулна уу.

- | | |
|------------------------|----------------------|
| 1) Өмнөд Георгийн арал | a) Умард мөсөн далай |
| 2) Галапагос арал | b) Номхон далай |
| 3) Мальдивийн арлууд | c) Энэтхэгийн далай |
| 4) Шпицбергений арал | d) Атлантын далай |
- A. 1d, 2b, 3c, 4a
 B. 1a, 2d, 3b, 4c
 C. 1c, 2a, 3d, 4b
 D. 1b, 2d, 3c, 4a
 E. 1a, 2b, 3d, 4b

35. 5 цагийн хугацаанд дэлхий тэнхлэгээ хэдэн градусаар эргэх вэ?

- A. 60° B. 75° C. 30° D. 55° E. 45°

36. Дэлхийд төмрийн хүдрийн болон байгалийн хийн нөөцөөр 1-р байр, чулуун нүүрсээр 3-р байр, газрын тосны нөөцөөр 7-р байр эзэлдэг улсын нийт төмөр замын урт нь 90 гаруй мянган км бөгөөд цахилгаанжсан төмөр замын уртаар дэлхийд тэргүүлдэг. Энэ аль улс вэ?

- | | |
|-----------|---------|
| A. Герман | D. Япон |
| B. Швед | E. ОХУ |
| C. Канад | |

37. 2006 онд 15 аймгийн 69 сум, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт 164 удаа удаа түймэр гарсны улмаас ойн 391761 га талбай, хээрийн 5202195 га талбай шатсан. Нийт хэдэн км² газар түймэрт өртсөн бэ?

- A. 5593,956 км²
 B. 5503956 га
 C. 5593956 га
 D. 55939,56 км²
 E. 5503,956 км²

38. Персийн булангаас Япон, Баруун Европ ба АНУ, Баруун Сибирээс Европруу, Карибын тэнгисээс АНУ-руу чиглэсэн тээвэрлэлтийн урсгалыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Газрын тосны
- B. Машин, цахилгаан- радио техникийн
- C. Автомашины
- D. Төмрийн хүдэр, үнэт модны
- E. Бэлэн хувцас, гоо сайхны барааны

39. Байгалийн унаган төрхийг хамгаалах төрөл бүрийн арга зам байдаг. Манай улсын тусгай хамгаалалттай 61 газар байдаг. Эдгээрээс доор өгөгдсөн газруудыг орших аймагтай нь харгалзуулснаас зөвийг нь сонгоно уу.

- | | |
|------------------|-----------|
| 1) Түргэн уул | a) Увс |
| 2) Хустайн нуруу | b) Завхан |
| 3) Отгонтэнгэр | c) Булган |
| 4) Уран уул | d) Төв |
- A. 1a, 2b, 3c, 4d
 B. 1b, 2d, 3c, 4a
 C. 1b, 2a, 3d, 4c
 D. 1a, 2d, 3b, 4c
 E. 1b, 2c, 3d, 4a

40. Хүснэгтэнд өгөгдсөн мэдээллийг зөв тохируулна уу.

Тэнгисийн нэр	дугаар	Далайн нэр	Тэмдэглэгээ
Арабын	1	Номхон	a
Карибын	2	Умард мөсөн	b
Филлиппиний	3	Атлантын	c
Лаптевын	4	Энэтхэгийн	d

- A. 1c, 2a, 3d, 4b
 B. 1d, 2b, 3a, 4c
 C. 1b, 2a, 3c, 4d
 D. 1d, 2c, 3a, 4b
 E. 1b, 2d, 3c, 4a


41. Хүн ам нь 100 саяас доош, газар нутгийн хэмжээ нь 1 сая км²- аас их улс орнууд аль нь вэ?

- A. Австрали, Канад, Чили, Энэтхэг, ОХУ
 B. Иран, Индонез, Перу, Мексик, Конго
 C. Саудын Араб, Алжир, АНУ, Өмнөд Солонгос, ОХУ
 D. Аргентин, АНУ, ОХУ, Монгол, Япон
 E. Испани, Энэтхэг, Герман, Алжир, Вьетнам

42. Энэ бүсийн ихэнх улсуудын албан ёсны хэл нь испани бөгөөд хамгийн өндөр хөгжилтэй улс нь Мексик. Эдийн засгийн гол салбарууд нь ургамлын аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбарууд байдаг бол энэ аль бүс нутаг вэ?

- | | |
|-----------------|----------------|
| A. Европ | D. Төв Америк |
| B. Өмнөд Ази | E. Хойд Америк |
| C. Өмнөд Америк | |

43. Хуурай уур амьсгалтай, элсэн цөлд Лас Вегас хот байгуулсан ба уур амьсгалд нь нөлөөлдөг далайн урсгалыг хэдийн тоогоор тэмдэглэсэн вэ?




- A. 6
 B. 7
 C. 5
 D. 4
 E. 1

44. Агаар бохирдуулагч элемент ба түүний эх үүсвэрийг зөв харгалзуулна уу.

- | | |
|--------------------------|---|
| 1) Метан бус гидрокарбон | a) Гэрэлтүүлэг, хөрсний микробууд, биомассын шаталт |
| 2) Нүүрсхүчлийн хий | b) Далайн давс, тоос шороо |
| 3) Азотын ислүүд | c) Амьсгал, түлшний шаталт, үйлдвэр |
| 4) Суспензууд | d) Бүрэн бус шаталт, биомассын шаталт |


- A. 1a, 2c, 3d, 4b
 B. 1c, 2d, 3b, 4a
 C. 1b, 2d, 3a, 4c
 D. 1d, 2b, 3c, 4a
 E. 1d, 2a, 3b, 4c

45. Дараах зурагт тохирох хамгийн оновчтой үг аль нь вэ?




- A. Хөдөө
 B. Хот
 C. Агломераци
 D. Дэд бүтэц
 E. Гадаад шилжилт

46. Дараах зурагт гуравдагч үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын хувь хэмжээгээр хамгийн их улс хэдийн тоогоор тэмдэглэгдсэн бэ?




- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5

47. Хоёрын тоогоор хотын ямар функцийг тэмдэглэсэн бэ?




- A. Орлого багатай иргэдийн орон сууц
- B. Дундаж орлоготой иргэдийн хороолол
- C. Захын бизнес дүүрэг
- D. Хүнд аж үйлдвэр
- E. Бөөний худалдаа, хөнгөн үйлдвэр

48. Жуулчин Б цэгт Оранж голын хойд хэсгээр аялаад, Конго мөрний сав газар А цэгт очсон бол байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон бэ?




- A. Саванны бүсээс цөлийн бүс рүү
- B. Саванны бүсээс хатуу навчит ой , бутлаг ургамлын бүс рүү
- C. Экваторын чийглэг ойгоос саванны бүс рүү
- D. Экваторын чийглэг ойгоос цөлийн бүс рүү
- E. Цөлийн бүсээс экваторын чийглэг ойн бүс рүү

49. 2006 он гарсаар Архангай аймагт 4, Ховд аймагт 1, Завхан аймагт 1, Хөвсгөл 1 удаа, нийт 7 удаа аадар бороо, үер буусны улмаас 3650 толгой мал хоргоджээ. Монгол улсын газрын зурагт эдгээр аймгуудыг хэдийн тоогоор тэмдэглэсэн вэ?



- A. 8, 5, 6, 11
- B. 11, 8, 5, 12
- C. 12, 11, 6, 15
- D. 14, 8, 11, 6
- E. 13,14, 12, 11

50. Д цэг дээр агаарын температур $-7,5^{\circ}\text{C}$ байсан бол Г цэг дээр хэдэн хэм байхыг бодож олно уу?



- A. $1,3^{\circ}\text{C}$
- B. $-2,6^{\circ}\text{C}$
- C. $4,5^{\circ}\text{C}$
- D. $1,5^{\circ}\text{C}$
- E. $-4,5^{\circ}\text{C}$

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТООЦООЛОХ ДААЛГАВАР

Санамж: Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудсанд дараах байдлаар тэмдэглэнэ үү. *Жишээлбэл:*

- Эцсийн хариу 342 гэж гарсан бол a-3, b-4, c-2 гэж бөглөнө.
- Нарны өндөр олох бодлогын хариу $75^{\circ}28'$ гэж гарсан гэж үзвэл a-7, b-5, c-2, d-8 гэж бөглөнө.

2.1. Улаанбаатар хот х.ө $47^{\circ}55'$, з.у 107° оршдог. Тэгвэл 6 дугаар сарын 22-нд үдийн нарны өндөр хэдэн градус, хэдэн минут байхыг бодож олно уу.

2.2. 1:1000000 масштабтай зураг дээр 2 см зурагдсан зай 1:25000 масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. з.у 47° - т орших нутагт 16 цаг болж байхад Улаанбаатар хотод хэдэн цаг болж байх вэ?

2.4. Тухайн голын өргөн 20 м, голын хамгийн гүн хэсэг нь 6 м бол голын хөндлөн огтлолын талбай хэдэн м^2 байх вэ?